



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Утасны 09 дугаар сарын 13
№34 /655/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

1372

**“Шинэ бүтээн байгуулалт” дунд
хугацааны зорилтот хөтөлбөр
батлах тухай**

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

1388

**Таван толгойн нүүрсний ордыг
ашиглах зарим асуудлын
тухай**

Монгол Улсын
Васгийн газрын
тогтоол

1402

**Үндэсний хөтөлбөр батлах
тухай**



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

296.	Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1370
297.	Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1370
298.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1371
299.	Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд нэмэлт оруулах тухай	1371
300.	Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1372

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

301.	"Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай	Дугаар 36	1372
302.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 38	1388
303.	Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай	Дугаар 39	1388
304.	Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөдлийг зөвшөөрөх тухай	Дугаар 40	1389
305.	Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 41	1396
306.	Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 42	1398
307.	Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг чөлөөлөх тухай	Дугаар 43	1398
308.	Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай	Дугаар 44	1399

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

309.	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 138	1399
310.	Олон улсын хурал зохион байгуулах тухай	Дугаар 139	1402
311.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 141	1402
312.	Хамгаалалтын захиргаа байгуулах тухай	Дугаар 147	1420



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2010 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмсүгэй:

"5 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 40.0 тэрбум төгрөгөөр баталсугай."

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн хүснэгтийн 2 дахь заалтын "145,699.1" гэснийг "149,520.3" гэж, 3 дахь заалтын "57,498.8" гэснийг "61,726.6" гэж, мөн хүснэгтийн 9 дэх заалтын "649.5" гэснийг "699.2" гэж, мөн хүснэгтийн "346,846.2" гэснийг "354,944.9" гэж, 4 дүгээр зүйлийн хүснэгтийн 1 дэх заалтын "342,889.7" гэснийг "368,586.7" гэж, мөн хүснэгтийн 3 дахь заалтын "16,270.0" гэснийг "17,360.2" гэж, мөн хүснэгтийн 6 дахь заалтын "9,239.0" гэснийг "9,787.8" гэж, мөн хүснэгтийн "490,935.3" гэснийг "518,271.3" гэж, мөн хуулийн 5 дугаар зүйлийн дугаарыг "6" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2010 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн "39,900.0 сая төгрөг" гэснийг "40,954.2 сая төгрөг" гэж, мөн зүйлийн 3.2 дахь хэсгийн "94,033.3 сая төгрөг" гэснийг "110,016.1 сая төгрөг" гэж, мөн зүйлийн 3.3 дахь хэсгийн "212,730.0 сая төгрөг" гэснийг "70,910.0 сая төгрөг" гэж, 5 дугаар зүйлийн "11,757.2 сая төгрөг" гэснийг "28,794.2 сая төгрөг" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн "томоохон арга хэмжээг тусгана" гэснийг "томоохон арга хэмжээ, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдаа, хөрөнгийн эх үүсвэр, хариуцан хэрэгжүүлэх яам, байгууллагыг тусгана" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИД БАТАЛГАА ГАРГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкн дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэг:

"2.5.Банк энэ хуулийн 2.1-д заасан баталгаанд хамаарах иргэдийн мөнгөн хадгаламжийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэлийг жил бүр Засгийн газрын Монголбанкн дахь тусгай дансанд төвлөрүүлнэ."

2/2' дүгээр зүйлийн 2'.1.4-2'.1.6. дахь заалт:

"2'.1.4.Банк хоорондын захаас болон гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн мөнгөн хадгаламж, харилцах дансны үлдэгдэл;

2'.1.5.Банкинд зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын өр төлбөртэй этгээд, түүний холбогдох этгээдийн мөнгөн хадгаламж, харилцах дансны үлдэгдэл;

2'.1.6.Монголбанкны бодлогын хүүгийн хэмжээнээс дээш давсан мөнгөн хадгаламжийн хүү."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалтын "мөнгө, зээл" гэснийг "мөнгө, зээлийн тодорхой хэсэг" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 06 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

"Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2."Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т үүрэг болгосугай:

1/Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж эхлэх;

2/тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 2010 оны намрын, 2011 оны хаврын ээлжит чуулганд тус тус өргөн мэдүүлэх;

3/Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр"-ийн биелэлтийг хоёр жил тутам гаргаж Улсын Их Хуралд

танилцуулах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг гарсантай холбогдуулан "Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2007 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 46 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

**Монгол Улсын Их Хурлын 2010 оны
36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

**"ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" ДУНД
ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР**

Нэг.Хөтөлбөрийн зорилго

Монгол Улсын хэмжээнд бүтээн байгуулалтыг өрнүүлснээр хот төлөвлөлт, эрчим хүч, инженерийн дэд бүтэц, авто замын сүлжээг олон улсын жишигт хүргэх, хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, иргэдийг ажлын байраар хангах замаар улсын хэмжээнд тулгараад байгаа эдийн засаг, нийгмийн бэрхшээлтэй асуудлуудыг цогцоор шийдэн хөгжлийг жигд хангах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь ханган баталгаажуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр.Хөтөлбөрийн шаардлага, үндэслэл, бүтэц

2.1. Хөтөлбөрийн шаардлага, үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтад "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.2-т "Хүн амын дотоодын шилжилт хөдөлгөөнийг бодлогоор зохицуулж, бүс болон бүсийн тулгуур төв, дагуул хотуудын төлөвлөлт, удирдлагыг сайжруулан, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана" гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

"Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги" зэрэг бодлогын баримт бичгүүд, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын



тухай хууль болон зах зээлийн тогтолцоонд шилжиж эхэлсэн үеэс өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн хөгжлийн бодлогын бусад баримт бичгийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар нь энэхүү хөтөлбөрийн үндэслэл болно.

Газар зохион байгуулалт, хот байгуулалт, төлөвлөлтийн нэгдсэн бодлого хэрэгжээгүйн улмаас дэд бүтцийн хангамж, нийгмийн үйлчилгээний хүртээмж, хот орчмын экологийн доройтол бий болж, хүн амын эрүүл мэндэд хохирол учруулах хэмжээнд хүрч байгаа нь "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-ийг боловсруулах үндсэн шалтгаан болж байна.

Улаанбаатар хотын хүн амын механик өсөлт нэмэгдсээр байна. Макро эдийн засгийн бодлого оновчгүй, үйлдвэрлэл хөгжөөгүй, дэд бүтэц хангалтгүйгээс шинээр ажлын байр бий болгох боломж хомс байна.

Дээр дурдсан болон бусад тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд хот байгуулалт, төлөвлөлтийн шинэлэг бодлого, зохицуулалт, гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх, улсын чанартай авто замын сүлжээ, орон нутагт чиглэсэн бүтээн байгуулалтын зорилтот хөтөлбөрийг баталж, салбаруудын хөгжлийн төсөл, хөтөлбөрийг уялдаатайгаар хэрэгжүүлэх шаардлагатай тулгарч байна.

Ийнхүү бүтээн байгуулалт өрнөснөөр иргэд тогтвортой ажлын байртай, орлоготой болж, үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан зээлийн тогтолцоо бүрдэх, гэр хороолол орон сууцны цогцолбор хороолол болон өөрчлөгдөх, хүрээлэн байгаа орчны чанарыг илтгэх агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах боломж бүрдэнэ.

Дээрхи үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бий болгох, хөдөлмөрийн болон санхүүгийн зах зээлийг орчин цагийн шаардлага хангахуйц түвшинд хүргэж хөгжүүлэх шаардлагатай.

2.2.Хөтөлбөрийн бүтэц

Энэхүү хөтөлбөрт Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Хотууд", "Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл", "Хөдөөгийн хөгжил", "Орон сууц" бодлогын баримт бичгийн хүрээнд хийгдэх ажил багтана.

Түүнчлэн "100 мянган айлын орон сууц", "Барилгын материалын үйлдвэр" зэрэг төслүүдийн хүрээнд хийгдэх ажлуудыг нэгтгэсэн болно.

Гурав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

3.1.1.төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлд тулгуурлах;

- 3.1.2.үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх;
- 3.1.3.импортыг орлох чадвартай дотоодын үйлдвэрлэлийг дэмжих;
- 3.1.4.бүтээн байгуулалтын ажилд иргэдийг мэргэжил эзэмшүүлэх замаар татан оролцуулах;
- 3.1.5.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлж дүгнэх хариуцлагын тогтолцоо бий болгох.

Дөрөв.Хөтөлбөрийн зорилт, хамрах хүрээ, хугацаа, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ:

4.1.1.Хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр:

4.1.1.1.хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтын оновчтой бодлого хэрэгжүүлэх замаар хот, суурины газар ашиглалтыг сайжруулж, эрчим хүч, авто зам, инженерийн дэд бүтцийг шинэ түвшинд хөгжүүлэх;

4.1.1.2.Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдийн 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон шинээр төлөвлөх, тэдгээрийг хэрэгжүүлэх;

4.1.1.3.хот байгуулалт, төлөвлөлтийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;

4.1.1.4.хот, суурины газар ашиглалт, түүний олголтыг бодлогоор зохицуулах, гэр хорооллыг оршин суугчдынх нь оролцоотойгоор орон сууцны хороолол болгон хөгжүүлэх;

4.1.1.5.уул уурхайг түшиглэсэн хот, сууриныг хөгжүүлэх.

4.1.2.Дэд бүтцийн чиглэлээр:

4.1.2.1.Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, орон нутагт эрчим хүчний төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрийг бий болгох;

4.1.2.2.аймгийн төвүүдийг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбох, сэргээгдэх эрчим хүчний шинэ техник, технологийг нэвтрүүлэх;

4.1.2.3.барилга, байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах;

4.1.2.4.Улаанбаатар хот, аймаг, орон нутгийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийх, шинээр барьж ашиглалтад оруулах;

4.1.2.5.Улаанбаатар хотын авто замыг шинэчлэн сайжруулах, Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй, аймгийн төвийг ойролцоох хилийн боомттой холбосон улсын болон олон улсын чанартай



авто замын сүлжээг бий болгох;

4.1.2.6.гүний болон гадаргын цэвэр усан хангамжийн шинэ эх үүсвэрийг бий болгох.

4.1.3.Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

4.1.3.1.хөтөлбөрийн 2.2-т заасан "100 мянган айлын орон сууц" төслийг Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, сумын төвүүдэд хэрэгжүүлэх;

4.1.3.2.орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, худалдаа, үйлчилгээний төв, ногоон байгууламжийн хамт цогцоор нь барих;

4.1.3.3.газар хөдлөлтийг тэсвэрлэхгүй орон сууцны барилга байгууламжийг буулган оронд нь орон сууцны шинэ хороолол, цогцолбор барьж байгуулах;

4.1.3.4.бага, дунд орлоготой иргэдийг орон сууцны урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах замаар орон сууцны эрэлтийг дэмжиж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх.

4.1.4.Ажлын байр нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих чиглэлээр:

4.1.4.1.мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд мэргэжил эзэмшүүлэх замаар ажилгүй иргэдийг ажлын байраар ханган амьжиргааны түвшинг нь дээшлүүлэх;

4.1.4.2.бүсийн тулгуур төв, аймаг, орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажлын байр бий болгох;

4.1.4.3.их, дээд сургуулиудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлж хотхон болгон хөгжүүлэх.

4.1.5.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр:

4.1.5.1.хотын тоос, утаа, тортог, хог хаягдлыг багасгах, мод, зүлэг зэрэг ногоон байгууламжийн нэг хүнд ногдох хэмжээг 20 м2 хүртэл нэмэгдүүлэх;

4.1.5.2.гэр хорооллын айл өрхийн зуух-яндан-түлшний бүтэц, шаталтын технологийг өөрчлөн сайжруулах, нам даралтын уурын зууханд технологийн шинэчлэл хийх, гэр, орон сууцны дулаалгыг сайжруулах замаар түүхий нүүрсний хэрэглээг багасгаж, утаа, тортогны ялгаралтыг 50 хүртэл хувиар бууруулах;

4.1.5.3.Улаанбаатар хотод байгаа төвлөрсөн халаалтын болон аж ахуйн нэгж, байгууллагын ашиглаж байгаа нам даралтын уурын зуух, мөн гэр хорооллын түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хязгаарлан, улмаар утаагүй түлш, шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг шинэ технологи нэвтрүүлэх замаар утаа, хорт хийн ялгаралтыг 2013 он хүртэл хугацаанд 60-аас доошгүй хувиар бууруулах;

4.1.5.4.хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн хэрэгслийг байгалийн шатдаг хий, цахилгаан эх үүсвэрт

шилжүүлж, автотээврийн хэрэгслээс ялгарах утааг бууруулах цогц арга хэмжээ авах;

4.1.5.5. хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгах технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлэх;

4.1.5.6. олон улсын стандартад нийцээгүй, байгаль орчныг бохирдуулж байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг Монгол Улсад экспортлохгүй байх талаар холбогдох гэрээ, хэлэлцээрийг тухайн улс орнуудтай байгуулах;

4.1.5.7. стандартын шаардлага хангаагүй бүх төрлийн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээг тодорхой үе шаттай авч хэрэгжүүлэх.

4.1.6. Хөдөөгийн хөгжлийг дэмжих чиглэлээр:

4.1.6.1. бүсийн тулгуур төв, аймаг, сумдад эмнэлэг, сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, худалдаа, үйлчилгээ зэрэг нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг барьж хүн амын соёл, боловсрол, эрүүл мэндийн болон бусад төрлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.1.6.2. хот байгуулалт, төлөвлөлтийн бодлоготой уялдуулан орон сууц барих үйл ажиллагааг төлөвлөгдсөн суурьшлын бүсэд хурдацтай хөгжүүлэх;

4.1.6.3. төвөөс алслагдсан, хөгжлөөр сул бүс нутаг, аймгийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар нийгэм, эдийн засгийг нь түлхүү хөгжүүлэх;

4.1.6.4. аймаг, орон нутгийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан жижиг, дунд үйлдвэр, үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар шилжилт хөдөлгөөнийг сааруулах.

4.1.7. Үйлдвэржилтийг дэмжих чиглэлээр:

4.1.7.1. барилгын ажилд байгаль орчинд хоргүй, дулаанд хэмнэлттэй шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлж, байгалийн нөөцийн зохистой хэрэглээг хангах;

4.1.7.2. хөтөлбөрийн 2.2-т заасан "Барилгын материалын үйлдвэр" төслийн хүрээнд аймаг, нийслэл, бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын үйлдвэр, үйлдвэрлэл, технологийн парк, материалын сорилт, шинжилгээний иж бүрэн лаборатори байгуулан, улмаар нэмүү өртөг шингэсэн, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үндэсний компаниудын үйлдвэрлэсэн барилгын материалын хэрэглээг дэмжих;

4.1.7.3. газрын тос, байгалийн хий, биоэтанол, биодизель, димэтилэфир, нийлэг дизель түлшний үйлдвэрлэлийг дэмжих.

4.1.8. Шилжилт хөдөлгөөнийг сааруулах чиглэлээр:

4.1.8.1. орон нутгаас Улаанбаатар хот руу



чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулах, хотын төвлөрөл, эмх замбараагүй тэлэлтийг бууруулах зорилгоор Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, сумдыг цогцоор хөгжүүлэх;

4.1.8.2.Улаанбаатар хотод сууршихаар ирж байгаа иргэдийн суурьшлыг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.1.8.3.Бүсийн тулгуур төвүүдэд оюутны хотхон шинээр байгуулан Улаанбаатар хотод төвлөрсөн их, дээд сургуулиудын тоог цөөрүүлэх замаар нийслэл рүү шилжин суралцах оюутнуудын тоог бууруулах;

4.1.8.4.төвөөс алслагдсан, хөгжлөөр сул бүс нутаг, аймгуудын иргэдэд бүс нутгийн нэмэгдэл олгох, банк, санхүү, татвар, зээлийн бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх.

4.2.Хөтөлбөрийн хамрах хүрээ

4.2.1.хөтөлбөрийг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан хэрэгжүүлнэ.

4.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

4.3.1.Хөтөлбөр нь 2010-2016 оны хооронд дараахь үе шаттайгаар хэрэгжинэ:

4.3.1.1.нэгдүгээр үе шат: 2010-2012 он;

4.3.1.2.хоёрдугаар үе шат: 2013-2016 он.

4.4.Хөтөлбөрийн зорилтуудад хүрэхийн тулд дараахь үйл ажиллагаа явуулна:

4.4.1.Хот байгуулалт, төлөвлөлтийн зорилтын хүрээнд:

4.4.1.1.хотууд болон бүсийн тулгуур төвүүдийг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж мөрдүүлэх, 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг газар зохион байгуулалт, барилгажилт, газар хөдлөлийн мужлал, нийтийн тээврийн сүлжээний оновчтой шийдлийг харгалзан боловсруулах;

4.4.1.2.улсын, бүсийн, аймгийн, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг бусад холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, байгаль орчинд ээлтэй, үргүй зардлыг багасгасан, эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд чиглэсэн байдлаар боловсруулж мөрдүүлэх;

4.4.1.3.байгаль орчны бохирдол үүсгэгч үйлдвэр, онцгой объект, их, дээд сургуулийн цогцолборыг нийслэлээс нүүлгэх;

4.4.1.4.Улаанбаатар хотын гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;

4.4.1.5.хот байгуулалт, төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, дүрэм, журам, норм, норматив, стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах;

4.4.1.6.хот байгуулалт, төлөвлөлтийг зохион байгуулахдаа инженерийн барилга байгууламж, нийтийн тээвэр, агаарын тээвэр, нийтийн аж ахуй, орон сууц, гэр хороолол, нийгмийн дэд бүтэц, газар ашиглалт зэргийг харгалзан олон улсын жишигт нийцүүлэн төлөвлөх;

4.4.1.7.уул уурхай, үйлдвэрийг түшиглэн шинээр хот, суурин газруудыг төлөвлөн барьж байгуулах.

4.4.2.Дэд бүтцийн зорилтын хүрээнд:

4.4.2.1.шинээр болон шинэчлэн баригдах суурин газар, орон сууцны цогцолбор хорооллыг байгаль орчинд ээлтэй, бие даасан дулаан, цэвэр, бохир усны инженерийн дэд бүтцийн хамтаар бүтээн байгуулах;

4.4.2.2.суурин газар болон орон сууцны цогцолбор хорооллуудын эрчим хүчний хангамжийн тодорхой хэсгийг тухайн нөхцөлд тохирсон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах замаар хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, эдийн засгийн үр ашигтай хэлбэрт шилжүүлэх;

4.4.2.3.эрчим хүчний 5 дахь эх үүсвэрийг барьж ашиглалтад оруулах;

4.4.2.4.Улаанбаатар хотод цахилгааны 110 кВт-н "Их тойруу" цагираг шугам сүлжээ байгуулах;

4.4.2.5.Улаанбаатар хотын "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК, "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн үйлдвэрийн уурын нөөцийг дулаан үйлдвэрлэх зориулалтаар ашиглах, Буянт-Ухаа, 7, 14 дүгээр хороолол, Монголын олон нийтийн радио телевизийн орчим, Зүүн Сэлбэ хорооллын шугам сүлжээг барих, "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-иас Баянгол амын чиглэлийн дулааны шугам сүлжээг ашиглалтад оруулах;

4.4.2.6.Улаанбаатар хотын гэр хорооллын 2500 айл өрхийг төвлөрсөн дулаан хангамжид хэсэгчилэн холбох;

4.4.2.7.Улаанбаатар хотод "Гацуурт", "Буянт-Ухаа" гүний усны эх үүсвэр, "Туул усан цогцолбор" далан барьж ашиглалтад оруулах;

4.4.2.8.Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд хор нөлөөгүй технологиор шинэчлэн сайжруулах;

4.4.2.9.Улаанбаатар хотын хэмжээнд хаягдал (саарал) ус, лагийг дахин ашиглах технологийн шинэчлэл хийх;

4.4.2.10.Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй, аймгийн төвүүдийг ойролцоох хилийн боомтуудтай холбосон 5572 км авто зам барих;

4.4.2.11.Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 990 км хурдны замыг барьж ашиглалтад оруулах;

4.4.2.12.Улаанбаатар хотын авто замын 1, 2, 3 дугаар тойрог замыг шинээр бий болгох, тойрог замыг холбосон туслах зам, хотын алслагдсан дүүрэг, шинээр баригдсан орон сууцны цогцолбор хорооллуудыг холбосон авто зам барих, шинэчлэн сайжруулах, Хөшигийн хөндийн нисэх буудалтай холбосон шинээр нийт 212 км авто зам,



шинэчилсэн 350 км авто зам, 2 түвшний гүүрэн 7 гарц барих.

4.4.3.Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

4.4.3.1."100 мянган айлын орон сууц" төслийн хүрээнд Улаанбаатар хотын батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 35 байршилд 80 мянгаас доошгүй айлын орон сууцны цогцолбор хороолол, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдэд 25 мянга хүртэлх айлын орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, бие даасан болон төвлөрсөн эх үүсвэртэй инженерийн дэд бүтэц, ногоон байгууламжийн хамтаар барих;

4.4.3.2.шинэ орон сууцны цогцолбор хорооллын нутаг дэвсгэрийн хэмжээнд газар ашиглалтын байдлын зураглал хийх, газар ашиглалт, үл хөдлөх хөрөнгийн судалгаа гаргах, зохистой төлөвлөлттэй цогцолбор хороолол барих;

4.4.3.3.гэр хорооллыг нэн тэргүүнд дэд бүтэцтэй болгоход улсын төсөв болон бусад орлогын үүсвэрийг зориулах, түүнчлэн гэр хорооллын айл өрхийг дэд бүтэцтэй өртөг нэмэгдсэн газраа барьцаалан орон сууцтай болох, орон сууцны зээлд хамрагдах бололцоогоор ханган амины орон сууц барих төсөл хэрэгжүүлэх;

4.4.3.4.Улаанбаатар хотын гэр хорооллыг инженерийн дэд бүтэцтэй болгох, гэр хорооллын өрхүүдийг орон сууцанд орох нөхцөлийг бүрдүүлэхдээ хот төлөвлөлтийн судалгаанд үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 32100-аас доошгүй орон сууцыг ашиглалтад оруулах;

4.4.3.5.эрсдэлтэй бүсэд суурьшиж байгаа 14400 айлыг суурьшлын шинэ бүсэд нүүлгэн шилжүүлэх;

4.4.3.6.Улаанбаатар хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоо байгаа гэр хорооллын 557,8 га газрыг чөлөөлөх;

4.4.3.7.Улаанбаатар хотын "Шинэ Яармаг", "Буянт-Ухаа", "Баянголын ам", "Ирээдүй хороолол", "Ургах наран", "Эрин хотхон" зэрэг хүн амын шинэ суурьшлын бүсэд 20000 орчим айлын орон сууц, Дархан хотын 13 дугаар хороололд 2000 айлын орон сууц барих;

4.4.3.8.газар хөдлөлтийг тэсвэрлэхгүй, бат бэх чанараа хангахгүй болсон барилга байгууламжийг буулгаж шинээр барьж байгуулах.

4.4.4.Ажлын байр нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих зорилтын хүрээнд:

4.4.4.1.хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд богино хугацааны сургалтад хамруулан ажлын байраар хангах;

4.4.4.2.бүтээн байгуулалтын ажилд шаардагдах

инженер техникийн ажилтан бэлтгэх;

4.4.4.3.шинээр баригдах орон сууцны хорооллыг жижиг, дунд бизнес эрхлэх ажлын байрны хамт цогцоор нь барих.

4.4.5.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд:

4.4.5.1.хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах хорооллуудын нийт талбайн 20 хувиас доошгүй хэсгийг ногоон байгууламжтай болгох;

4.4.5.2.гэр хорооллын 2300 га, нийтийн эзэмшлийн 1200 га талбайг зүлэгжүүлж, ойжуулан нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг хот төлөвлөлтийн стандартад хүргэх;

4.4.5.3.Улаанбаатар хотод байгаа оршуулгын газруудыг тохижуулах төсөл хэрэгжүүлэх;

4.4.5.4.бага, дунд хүчин чадал бүхий нам даралтын уурын зууханд технологийн шинэчлэл хийх;

4.4.5.5.гэрийн зуух-яндан-түлшний зохистой хувилбарыг сонгон шалгаруулж, эхний ээлжинд 10000 айл өрхөд хэрэглүүлэх арга хэмжээ авах;

4.4.5.6.монгол гэрийг иж бүрэн дулаалгаар хангах төсөл хэрэгжүүлж 60000 айл өрхийг хамруулах;

4.4.5.7.хагас коксон түлшний бөөний болон жижиглэнгийн худалдааны сүлжээг хөгжүүлэх;

4.4.5.8.гал ноцоогчийн зохистой хувилбарыг сонгон хэрэглээнд нэвтрүүлэх;

4.4.5.9.жилд 600 мянган тонн утаагүй түлш үйлдвэрлэх хүчин чадавхийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;

4.4.5.10.Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт утаатай түлшээр гэр халаахыг зөвшөөрөх бүсүүдийг нарийвчлан тогтоож ийнхүү зөвшөөрөгдсөн бүсээс бусад нутаг дэвсгэрт утаатай түлш хэрэглэхийг хориглох арга хэмжээ авах;

4.4.5.11.айл өрхийн зуухыг хийн түлшинд шилжүүлэх;

4.4.5.12.хагас коксон түлш үйлдвэрлэх, энэ түлшээр гэр хорооллын айл өрхийг хангах төслийг хэрэгжүүлэх бөгөөд нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх төслийн санхүүжилтийг 100 хувь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд төрөөс эдгээр компаниудад татвар, санхүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх;

4.4.5.13.төрийн байгууллага болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн өмчлөлд байгаа томоохон төвлөрсөн болон нам даралтын уурын зуухны түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж байгалийн шатдаг хий, цахилгааны эх үүсвэрээр ажилладаг технологид шилжүүлэх;

4.4.5.14.гэр хорооллын айл өрхийн түүхий



нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хязгаарлаж, утаагүй тулш, шатдаг хий, цахилгааны эх үүсвэрийг ахуйн зориулалтаар ашиглахад шинэ технологи нэвтрүүлэх, ингэснээр өрхийн зардал өнөөгийн түвшнээс илт нэмэгдсэн тохиолдолд төрөөс хамгийн зохистой дэмжлэгийг үзүүлэх;

4.4.5.15.хатуу хог хаягдлыг дахин боловсруулах диметилэфир, нийлэг тулш, барилгын материалын экологийн цэвэр үйлдвэрийн цогцолбор байгуулах;

4.4.5.16.нүүрс, нүүрсний давхаргын метан хийгээс диметилэфир, нийлэг тулш үйлдвэрлэж хот, суурин газрын нийтийн тээвэрт автомашин цэнэглэх 15-аас доошгүй станц бий болгох;

4.4.5.17.хур хогийг бүрэн цэвэрлэж, зайлуулж дуусгах;

4.4.5.18.барилгын хог хаягдлын зориулалтын цэг бий болгох;

4.4.5.19.агаарын бохирдлын эх үүсвэрийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэх;

4.4.5.20."Эко-бие засах газар" төсөл хэрэгжүүлэх;

4.4.5.21.гэр хорооллын айл өрхийг үнс түр хадгалах зориулалтын савтай болгох, улмаар үнс тээвэрлэх тусгай зориулалтын автомашины парк, гэр хорооллын үнсийг дахин боловсруулах үйлдвэрийг тус тус байгуулах;

4.4.5.22.Улаанбаатар хотын "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК, "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн үнсний савг цэцэрлэгжүүлж, байнгын усалгаатай болгох;

4.4.5.23.авто замын тоосыг соруулж өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг нь зориулалтын машин техникээр цэвэрлэдэг болгох;

4.4.5.24.нийтийн тээврийн том оврын 800, бага оврын 1500 автобусыг шингэрүүлсэн хийн түлшэнд шилжүүлэх;

4.4.5.25.тусгай замт автобусны үйлчилгээ, их багтаамжийн нийтийн тээврийн бусад төрлийг нэвтрүүлэх боломжийг судлах;

4.4.5.26.эхний ээлжинд 50 дуобус үйлдвэрлэхийн зэрэгцээ дизель хөдөлгүүртэй хуучин 100 автобусыг цахилгаан хөдөлгүүртэй болгох.

4.4.6.Хөдөөгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд:

4.4.6.1.бүсийн 8 тулгуур төв болон сум дундын төвүүдийн төлөвлөлтийг шинэчлэн сайжруулж, ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг цогцоор байгуулах;

4.4.6.2.улсын хэмжээнд "Сум дундын төв" загвар төслийг 96 байршилд хэрэгжүүлэх;

4.4.6.3.сум дундын төв, бүсийн тулгуур төвүүдийг

түшиглэн орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурласан ажлын байр бий болгох;

4.4.6.4. ижил төстэй байгаль, цаг уурын нөхцөлд туршигдсан барилгын технологийг нутагшуулах;

4.4.6.5. төвөөс алслагдсан, хөгжлөөр сул бүс нутаг, аймгуудын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төсөл боловсруулж, хөрөнгө оруулалтыг түлхүү хуваарилах;

4.4.6.6. төвөөс алслагдсан, хөгжлөөр сул бүс нутаг, аймгуудын иргэдэд бүс нутгийн нэмэгдэл олгох, банк, санхүү, татвар, зээлийн бодлогоор дэмжих;

4.4.6.7. бүсийн тулгуур төвүүдэд уул уурхай, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх иж бүрэн арга хэмжээ авах.

4.4.7. Үйлдвэржилтийг дэмжих зорилтын хүрээнд:

4.4.7.1. аймаг, нийслэл, бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, барилгын материалын үйлдвэр, үйлдвэрлэл, технологийн парк, материалын сорилт, шинжилгээний иж бүрэн лаборатори байгуулах;

4.4.7.2. аймаг, орон нутагт барилгын материалын түүхий эдийн геологи, хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх;

4.4.7.3. Нялга-Чойрын хүрэн нүүрсний сав газрын түүхий эдэд тулгуурлан нүүрс-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах;

4.4.7.4. "Агро-ойн хосолмол аж ахуй" болон өндөр технологийн "Шилэн дарлагын аж ахуй" хөгжүүлэх замаар эмийн бодис, хүнсний болон түлш, шатахууны зориулалттай биомасс үйлдвэрлэх цогцолбор байгуулах;

4.4.7.5. бүсийн тулгуур төвүүдэд хөдөө аж ахуйн түүхий эдэд суурилсан, эцсийн бүтэгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн парк, жижиг, дунд үйлдвэрүүд байгуулах;

4.4.7.6. ТЭЦ-2-ыг түшиглэн 200 мянган тонн утаагүй шахмал түлш үйлдвэрлэх төсөл гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх.

4.4.8. Шилжилт хөдөлгөөнийг сааруулах зорилтын хүрээнд:

4.4.8.1. аймаг, бүсийн тулгуур төвд оюутны хотхон бий болгох, их, дээд сургуулиудыг хотхон болгон хөгжүүлэх;

4.4.8.2. хүн амын шилжилт, хөдөлгөөнийг хот байгуулалтын бодлоготой уялдуулан орон сууц, нийгмийн үйлчилгээг нийслэлийн алслагдсан дүүргүүдэд хүргэх;

4.4.8.3. орон нутгаас шилжин ирэгсдийн урсгалыг ажлын байр бүхий суурьшлын бүсүүд рүү хандуулах;

4.4.8.4. газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

4.4.8.5. Улаанбаатар хотоос орон нутагт суурьших



асуудлыг оновчтой шийдвэрлэх.

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл

5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь арга хэрэгслийг ашиглана:

- 5.1.1.эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 5.1.2.эдийн засгийн хөшүүргийг хэрэглэх;
- 5.1.3.нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
- 5.1.4.мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;
- 5.1.5.төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 5.1.6.санхүүжилтийн шинэ эх үүсвэр бий болгох;
- 5.1.7.өндөр технологи нутагшуулах.

Зургаа.Хөтөлбөрийн санхүүжилт

6.1.Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- 6.1.1.концессын гэрээний дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүнд бий болсон хөрөнгө;
- 6.1.2.ашигт малтмалын ордоос уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гарган бүрдүүлсэн хөрөнгө;
- 6.1.3.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 6.1.4.Улаанбаатар хотын үндсэн хөрөнгийг барьцаалах замаар бүрдүүлсэн хөрөнгө;
- 6.1.5.олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 6.1.6.дараа эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний үндсэн дээр бизнес, хувийн хэвшлийн байгууллагаас гаргах хөрөнгө;
- 6.1.7.Засгийн газрын тусгай сан;
- 6.1.8.шинээр байгуулах Хөгжлийн банкны актив;
- 6.1.9.хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
- 6.1.10.ипотекийн хоёрдогч зах зээлээс үнэт цаас гаргасан эх үүсвэр;
- 6.1.11.бусад эх үүсвэр.

6.2.Хөтөлбөрийн зардлын дүн (2010-2016)

6.2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2010-2012 онд 8.8 их наяд, 2013-2016 онд 9.4 их наяд, нийт 18.2 их наяд төгрөг шаардагдах болно. Үүнд:

- 6.2.1.1.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 1.3 их наяд төгрөг;

6.2.1.2.эээл, тусламжийн санхүүжилт 0.09 их наяд төгрөг;

6.2.1.3.бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх 16.8 их наяд төгрөг.

6.3.Улаанбаатар хотод хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардлын дүн: 10.8 их наяд төгрөг.

6.4.Аймаг, бүсийн тулгуур төв, улсын чанартай авто замын сүлжээ зэрэг зам, тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардлын дүн: 7.5 их наяд төгрөг.

Долоо.Хөтөлбөрийн үр дүн

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

7.1.1.Улаанбаатар хотын агаарын бохирдол 2012 онд 30 хувиар, 2016 онд 50 хувиар тус тус буурах;

7.1.2.Улаанбаатар хотын утаанд эзлэх хорт бодисын агууламж 2012 онд 30 хувиар, 2016 онд 70 хувиар багасах;

7.1.3.хөрсний бохирдол 2012 онд 30 хувиар, 2016 онд 50 хувиар буурах;

7.1.4.Туул голын усны бохирдол 2012 онд 30 хувь, 2016 онд 50 хувь хувиар цэвэрших;

7.1.5.нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 20 м² талбай болж, байршил, суурьшлын зохистой байдал бүрдэх;

7.1.6.хотын хог, хаягдлын 50 хувийг 2012 онд, 70 хувийг 2016 онд дахин боловсруулах;

7.1.7.үндэсний чадамж бүхий барилга угсралт, авто замын болон барилгын материалын үйлдвэрлэл 2016 онд бий болох;

7.1.8.урт хугацаатай, бага хүүтэй орон сууцны эзэлийн тогтолцоо бүрдэх;

7.1.9.Улаанбаатар хотод 2012 онд 21600 орон сууц, 2016 онд 53400 орон сууц баригдаж ашиглалтад оруулснаар орон сууцны хангамж сайжрах;

7.1.10.Улаанбаатар хотод 2012 онд 112 км авто замыг шинээр, 150 км авто замыг шинэчлэн, 3 байршилд гүүрэн гарц, 2016 онд 100 км авто замыг шинээр, 200 км авто замыг шинэчлэн, 4 байршилд гүүрэн гарц тус тус ашиглалтад орж авто замын хөдөлгөөний түгжрэл буурах;

7.1.11.олон улсын болон улсын чанартай 1800 км авто замыг 2012 онд, 3752 км авто замыг 2016 онд тус тус ашиглалтад оруулснаар хөдөө орон нутагт хийгдэж байгаа тээвэрлэлтийн зардал буурч, логистикийн төвүүд хөгжих;

7.1.12.Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 990 км хурдны замыг 2014 онд барьж ашиглалтад оруулснаар экспорт, импортын тээвэрлэлтийн нөхцөл сайжрах.



Найм.Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх

8.1.Хөтөлбөрийн биелэлтийг үнэлэхэд дор дурдсан үзүүлэлтийг шалгуур болгоно:

- 8.1.1.хот төлөвлөлтийн бодлогын хэрэгжилт, үр дүнг;
- 8.1.2.инженерийн дэд бүтцийн хангамжийн түвшин, үүнд:
 - 8.1.2.1.эрчим хүчний хангамжийн түвшин, хүчин чадал;
 - 8.1.2.2.дулаан хангамжийн түвшин, хүчин чадал;
 - 8.1.2.3.цэвэр усан хангамжийн түвшин, хүчин чадал;
 - 8.1.2.4.мэдээлэл харилцаа холбооны хангамжийн түвшин;
 - 8.1.2.5.жил бүр ашиглалтад оруулсан авто замын уртын хэмжээ;
 - 8.1.2.6.хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн тоо, хүчин чадал;
- 8.1.3.Жил бүрийн хүн амын орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хангамжийн түвшин;
- 8.1.4.нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ;
- 8.1.5.Улаанбаатар хотын тоосжилтын хэмжээ;
- 8.1.6.хүн амын шилжилт хөдөлгөөний бууралт;
- 8.1.7.жил бүр шинээр бий болсон ажлын байрны тоо;
- 8.1.8.цэвэрлэх байгууламжуудын ашиглалтын үзүүлэлт.

8.2.Агаарын бохирдлыг үүсгэж байгаа хүчин зүйлүүдийн хувь хэмжээг жил бүр тодорхойлох замаар хөтөлбөрийн үр дүнд лабораторийн аргаар хяналт тавьж, тус улсын Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайланд тусгана.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт

Нэг.Шинээр батлах хуулийн төслийн жагсаалт:

1. Хот, суурины төлөвлөлтийн тухай хуулийн төсөл;
2. Хот, суурины төлөвлөлтийн бүсчлэл тогтоох тухай хуулийн төсөл;
3. Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл;
4. Газрын үнэлгээний тухай хуулийн төсөл;
5. Нийслэл хотын татварын тухай хуулийн төсөл;



6. Орон сууцны барилгыг шинэчлэн барих тухай хуулийн төсөл;
7. Барилгыг хуваан өмчлөх тухай хуулийн төсөл;
8. Хотыг дахин хөгжүүлэх /төлөвлөх/ тухай хуулийн төсөл;
9. Орон сууцны санхүүжилтийн тухай хуулийн төсөл;
10. Газар зохион байгуулалтыг шинэчлэх тухай хуулийн төсөл;
11. Газрыг улсын мэдэлд эгүүлэн татах тухай хуулийн төсөл;
12. Хурдны замын тухай хуулийн төсөл;
13. Авто зогсоолын тухай хуулийн төсөл;
14. Хог хаягдлыг хаях, ангилах, устгах, дахин ашиглах тухай хуулийн төсөл;
15. Бүсийн нэмэгдлийн тухай хуулийн төсөл.

Хоёр.Шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн жагсаалт:

1. Хот байгуулалтын тухай хууль;
2. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
3. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай;
4. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай;
5. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль;
6. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль;
7. Татварын ерөнхий хууль;
8. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль;
9. Орон сууцны тухай хууль;
10. Автотээврийн тухай хууль;
11. Барилгын тухай хууль;
12. Газрын тухай хууль;
13. Онцгой албан татварын тухай хууль;
14. Авто замын тухай хууль;
15. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль;
16. Захиргааны хариуцлагын тухай хууль;
17. Хүний хөгжил сангийн тухай хууль;
18. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /Шинэчилсэн найруулга/;
19. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хууль;
20. Ойн тухай хууль;
21. Иргэний бүртгэлийн тухай хууль;
22. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль;
- 23.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль;
24. Газрын төлбөрийн тухай хууль.

Гурав.Улсын Их Хурлын бусад шийдвэр:

- 1."Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл,



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дүгээр зүйлийн 22.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдөр "Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй хамтад нь өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Таван толгойн нүүрсний ордыг ашиглахтай холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/Таван толгойн нүүрсний ордод төрийн өмчит компани ашиглалтын үйлжиллагаа явуулах, "Эрдэнэс-Тавантолгой" охин компанийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуваахгүйгээр шилжүүлэх, түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, оператор аж ахуйн нэгжээр олборлолтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх;

2/Таван толгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэс-Таван толгой" компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг Монгол Улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах талаар дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх:

а/Монгол Улсын нийт иргэнд эхний ээлжинд хувьцааны 10 хувийг адил тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүй эзэмшүүлэх;

б/хувьцааны 10 хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах;

в/хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах;

З/“Эрдэнэс–Таван толгой” компанийн толгой компани болох “Эрдэнэс МГЛ” компанийг Монгол Улсын Үндсэн хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах асуудлыг судалж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах;

4/Таван толгойн нүүрсний ордыг түшиглэж үйлдвэр, зам, дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах, ашиглахад олон улсын жишиг стандартыг баримтлах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой уялдуулж, Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах, дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд авч хэрэглэх нөхцөл, болзлыг хэрэгжүүлэх;

5/дамжин өнгөрөх тээвэр, угтуулан тавих нөхцөл, урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, хөрөнгө оруулалт, борлуулалтын нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой нэгдсэн компани /консорциум/-ийг нээлттэй хэлбэрээр сонгон шалгаруулж хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлж, бусад баримт бичгийн төслийг танилцуулах.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг зөвшөөрөх тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын 2011 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2012-2013 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Монгол Улсын Засгийн газрын 2012-2013 оны дунд хугацааны зорилт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус зөвшөөрсүгэй.



2.Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуулийн төслийг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрсөн үзүүлэлтийг баримтлан боловсруулахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

3.Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэж батлахдаа энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрсөн үзүүлэлтийг баримталж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/, Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

**Монгол Улсын Их Хурлын 2010 оны
40 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт**

**МОНГОЛ УЛСЫН 2011 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2012-2013 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨӨЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсөөлөл		
		2011 он	2012 он	2013 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ, хувь	8.2	7.8	20.8
Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар				
2	Төсвийн нийт орлогын доод хэмжээ	35.4	35.4	30.3
3	Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	40.4	39.4	32.3
4	Төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээ	4.0	4.5	4.1
5	Төсвийн алдагдлын дээд хэмжээ	5.0	4.0	2.0
6	Хөрөнгийн зардлын доод хэмжээ	6.3	6.0	4.7

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2011-2013 ОНЫ
ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТ**

Монгол Улсын Засгийн газрын 2011-2012 оны дунд хугацааны зорилт нь хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, уул уурхайн болон нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын өрсөлдөх чадвар, бизнесийн орчныг сайжруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, төрийн удирдлагын ил тод, шуурхай, шударга, хариуцлагатай байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж ядуурал, ажилгүйдлийг бууруулахад чиглэнэ.

Нэг.Эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах чиглэлээр дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

1.1.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон бусад ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хувийн хэвшил, бодит салбарын үйлдвэрлэлийг дэмжих замаар дотоодын нийт бүтээгдэхүүний өндөр өсөлтийг хангах.

1.2.Инфляцийг нэг оронтой тоонд байлгаж, үүнийг хангахад чиглэсэн эдийн засгийн төсөв, мөнгөний бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэх.

1.3.Төлбөрийн тэнцлийн хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг болон гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.

Хоёр.Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

2.1.Төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор экспортод гаргаж байгаа ашигт малтмалын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн өсөлтөөс бий болсон орлогын тодорхой хувийг төсөвт төвлөрүүлэхээр татварын эрх зүйн орчныг өөрчлөх.

2.2.Орон нутгийн орлогын суурийг өргөжүүлэх, орон нутагт зарлагын зарим чиг үүргийг шилжүүлэх замаар орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, ижил тэгш, өрсөлдөх чадвартай эдийн засгийг хөгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг сайжруулах.

2.3.Төсвийн хамрах хүрээ, төлөвлөлт, хуваарилалт, хэрэгжүүлэлт, тайлагналт, хяналтын үе шатны бүх ажиллагаа, олон нийтэд ил тод байх нөхцөлийг хангах замаар хариуцлагын тогтолцоог сайжруулах.

2.4.Нийгмийн халамжийн нэгдсэн тогтолцоог бий болгох, давхардлыг арилгах, зорилтот бүлэгт чиглүүлэх замаар нийгмийн



хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэх.

2.5.Тэтгэврийн даатгалын сангийн "Эв санааны" тогтолцооноос хагас хуримтлалын, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих, нийгмийн даатгалын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг бэхжүүлж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх эхлэлийг тавих.

2.6.Зуд болон бусад байгалийн гамшгийн үед Засгийн газарт учрах ачааллыг бууруулах зорилгоор уламжлалт мал аж ахуйн байгалийн эрсдэл даах чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн "Малын индексжүүлсэн даатгал" төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.

2.7.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг олон улсын санхүүгийн зах зээлийн нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэн Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх.

2.8.Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, урт хугацаат зээлд хамруулах эх үүсвэрийг Засгийн газрын бондын эх үүсвэрээр бүрдүүлэх.

Гурав.Бизнесийн орчныг сайжруулах, үйлдвэржүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар бодит салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулах замаар экспортын уламжлалт болон шинэ бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг дэмжих.

3.2.Байгаль орчинд сөрөг нөлөөгүй цэвэр үйлдвэрлэл, өндөр технологийн чиглэлээр сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй шинжлэх ухаан, технологийн парк байгуулах, оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл хөгжих суурийг тавих.

3.3.Үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг шинээр байгуулах, өргөтгөх асуудлыг үйлдвэржилтийн бодлого, бүс нутгийн хөгжилтэй уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн хөгжүүлэх.

3.4.Олон улсын шилдэг стандартыг эдийн засаг, нийгмийн бүх салбарт нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

3.5.Стратегийн ордыг ашиглахад шаардагдах усан хангамж, зам харилцаа, байгаль орчны дэд бүтцийг барих, Оюу толгой, Таван толгой, Цагаан суваргын уурхайг байгуулах, бүтээгдэхүүнийг боловсруулах, баяжуулах үйлдвэрүүдийг барих ажлыг эхлүүлэх.

3.6.Стратегийн ач холбогдол бүхий нүүрсний орд газрыг түшиглэн цахилгаан станц байгуулж, үйлдвэрүүдийн болон бүс нутгийн цахилгаан, дулааны хэрэгцээг хангах.

3.7.Уул уурхайн цөөн төрлийн бүтээгдэхүүнээс хамаарсан эдийн засгийн хамаарлыг багасгах, боловсруулах аж үйлдвэрийг дэвшилтэт арга, технологиор хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний



үйлдвэрлэлийг дэмжих, эдийн засгийн суурь бүтцийг сайжруулах.

3.8.Өмнөговь, Чойр, Дархан-Сэлэнгийн бүс нутагт аж үйлдвэрийн цогцолбор байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх.

3.9.Улаанбаатар хот, бүсийн төв, хилийн томоохон боомтуудад ачаа, зорчигч тээврийн төрөлжсөн аж ахуй, авто замын гол сүлжээний дагууд үйлчилгээний дэд бүтцийг байгуулах.

3.10.Орон нутагт түүхий эдэд тулгуурласан, хүн амын хэрэгцээг хангахад чиглэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

3.11.Хөдөө аж ахуйн техникийн төрөлжсөн засвар, үйлчилгээний төвүүдийг бүсчлэн байгуулах, үр тариа, төмс, хүнсний ногооны механикжсан зоорь байгуулж хадгалалт, борлуулалтын сүлжээ бий болгоход дэмжлэг үзүүлэх.

3.12.Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжиж сүү, мах, ноос, ноолуур, арьс, шир боловсруулах үйлдвэрлэлд бохирдолгүй, хаягдалгүй орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортоос хараат байдлыг багасган үйлдвэрийн аргаар боловсруулсан эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр эко хүнсээр хүн амыг хангах.

3.13.Монгол малын тэсвэрт чанарыг хадгалан биологийн боломжийг нь бүрэн ашиглах, малын чанарыг сайжруулах замаар үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх.

3.14.Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн тэжээлийн ургамал, хадлан бэлтгэх, үр тариа, төмс, хүнсний ногоо тарих, хураах, ангилахад дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх.

3.15.Малын гаралтай түүхий эдийг стандартын дагуу бэлтгэн чанарын хамгаалалт хийж биржээр дамжуулан худалдаалах механизмыг бүрдүүлэх.

3.16.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж шягээр бизнес инкубатор төв байгуулан ажиллуулах, бизнес эрхлэх орчныг сайжруулах чиглэлээр үйл ажиллагааг нь идэвхжүүлэх.

3.17.Газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх.

3.18.Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх, технологи, инновацийг нэвтрүүлэн хөгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх.

3.19.Бага, дунд боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн шягчлэлийг гүнзгийрүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, сургалтын хөтөлбөрийг туршин нэвтрүүлэх.

3.20.Баг бүрт гэр цэцэрлэг байгуулах, хувилбарт сургалтын төрөл, хэлбэрийг олшруулах замаар сургуулийн өмнөх боловсролын хамралтыг нэмэгдүүлэх.

3.21.Багшийн мэргэжил дээшлүүлэх, чадавхийг нэмэгдүүлэх

бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох.

3.22.Мэргэжилтэй ажилтан бэлтгэх үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчтой холбох тогтолцоог төлөвшүүлэх, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоог зах зээлийн эрэлттэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх.

Дөрөв.Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхай, ногоон эдийн засгийг хөхиүлэн дэмжих чиглэлээр дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

4.1.Байгаль орчинд сөрөг нөлөөгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих эдийн засгийн урамшууллын механизмыг боловсронгуй болгох.

4.2.Геологи, уул уурхайн салбарын бодлогыг хариуцлагатай уул уурхайн зарчимд тулгуурлан шинэчлэн тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

4.3.Экологийн хувьд эмзэг, хамгаалалт шаардагдах ойн болон гол, мөрний эх, сав газраас бусад бүх газарт ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, технологи ашиглах нэгдсэн бодлогоор зохицуулах.

4.4.Уул уурхайн үйлдвэрлэлийн явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хохиролын экологи-эдийн засгийн үнэлгээг тооцон хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг сайжруулж, нөхөн сэргээлтийн чанарыг дээшлүүлэх иж бүрэн механизмыг бий болгох.

4.5.Хот, суурин газарт цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжих.

4.6.Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг дэмжих.

4.7.Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах "Ус хэмнэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх усны нөөцийн нэгдсэн менежмент, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах.

4.8.Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлогыг хэрэгжүүлж, ажлын байр шинээр бий болгох.

Тав.Иргэдээ эрүүл, чийрэг, боловсролтой, ажил орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

5.1.Иргэдийг нийгмийн баялгаас шударгаар хүртэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлж ажилгүйдлийн түвшинг бууруулах.



5.2. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, ялангуяа эрүүл мэнд, боловсрол, ядуурал, жөндөр, байгаль орчны талаар дэвшүүлсэн зорилтуудыг хангах ажлыг зохион байгуулах.

5.3. Нийгмийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, иргэдийг эрүүл, чийрэг амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

5.4. Хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, хүний нөөцийн мэдээллийн санг байгуулан ажиллуулах.

5.5. Эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбаруудад шаардлагатай хүний нөөцийг төлөвлөх, бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлэх.

5.6. Хөгжлийн бэрхшээлтэй болон өрх толгойлсон иргэдэд ажлын байр бий болгосон буюу ажлын байраар тогтвортой хангаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах тогтолцоог бий болгох.

5.7. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах орчин үеийн технологи бүхий үйлдвэрийг түүхий эдэд нь тулгуурлан аймаг, сумын түвшинд, экспортын чиглэлтэй үйлдвэрийг хил орчмын бүс нутагт барьж байгуулах аж ахуйн нэгжийг дэмжих ажлыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэн иргэдийг ажлын байраар хангах.

5.8. Үндэсний боловсролыг олон улсын түвшинд ойртуулах, бүх шатны боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлж, боловсролын салбарт олон улсын шилдэг стандартыг нэвтрүүлэн, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ур чадвартай мэргэжлийн ажилтан бэлтгэх.

5.9. Эрүүл мэндийн салбарын менежментийг боловсронгуй болгож, нийгмийн эрүүл мэндийг бодлогын цөм болгон хөгжүүлэх замаар эрүүл мэндийг дэмжсэн орчныг бүрдүүлэх, хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх.

5.10. Хүн амыг эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр жигд, хүртээмжтэй хангах, орчны бохирдлыг эрс багасгах, хүн амын ундны цэвэр усны хэрэгцээг хангах.

5.11. Шинээр бий болж байгаа болон дахин сэргэх халдварт өвчин, хорт хавдар, сүрьеэ өвчний өвчлөлөөс сэргийлэх тогтолцоог төлөвшүүлэх.

5.12. Хүн амын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын үйлчилгээнд зарцуулж байгаа хөрөнгийг үр ашигтай механизмаар нийгмийн эмзэг хэсэг, зорилтот бүлэгт оновчтой хүргэх, мөн хөдөөгийн болон алслагдсан бүс нутагт хүргэх оновчтой бөгөөд үр ашигтай бүтцийг бий болгох.

5.13. Нийгмийн даатгалын сангийн менежментийг боловсронгуй болгон хөгжлийн шаардлага, зах зээлийн жишигт нийцүүлэн хөгжүүлж, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах асуудлыг судлан шийдвэрлэх.



Зургаа.Төрийн үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах чиглэлээр дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

6.1.Яам агентлагуудад чиг үүргийн шинжилгээ хийх замаар төрийн байгууллагын бүтцийг боловсронгуй болгож, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжүүлж эхлэх.

6.2.Үйлчилгээний болон удирдлагын стандартыг боловсронгуй болгох, шат дамжлагыг цөөлөх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, орон нутгийн бие даасан байдлыг хангах, олон нийтийн зүгээс тавих хяналтын тогтолцоог сайжруулах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуулийн төсөл;

2/Хүний хөгжил сангийн 2011 оны төсвийн тухай хуулийн төсөл;

3/Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн тухай хуулийн төсөл;

4/"Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төсөл;

6/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/, Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл;

7/Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

8/Цагдаагийн байгууллагын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

9/Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төсөл;

10/Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;



11/Төсвийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

12/Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

13/Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

14/Бэлчээрийн тухай хуулийн төсөл;

15/Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

16/Зээлийн мэдээллийн тухай хуулийн төсөл;

17/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

18/Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

19/Монгол Улсын Эрүүгийн (Төрөлжсөн) хуулийн төсөл;

20/Казиногийн хуулийн төсөл;

21/Төрийн дээд цол, одон, медалийн тухай хуулийн төсөл;

22/Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хуулийн төсөл;

23/"Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

24/бусад.

2.Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, мөн энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг 2010 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр энэ тогтоолд заагаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас 2010 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор өргөн мэдүүлбэл намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4.Улсын Их Хурлын 2010 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Засгийн газар, Байнгын хороодын дарга, Улсын Их Хурал дахь намын бүлгийн ахлагч нар болон Тамгын газар /Ц.Шаравдорж/-г тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Улсын Их Хурлын гишүүн Содномзундуйн Эрдэнийг Хүний эрхийн дэд хорооны гишүүнээр баталсугай.
- 2.Энэ тогтоолыг 2010 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг чөлөөлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Наваансамдангийн Ганбямбыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээс чөлөөлсүгэй.
- 2.Энэ тогтоолыг 2010 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

**Санхүүгийн зохицуулах хорооны орон
тооны бус гишүүнийг томилох тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дэх хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Бяраагийн Мөнхбаатарыг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2010 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 06 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар
хот

**Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний талаар
авах зарим арга хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хүнсний тухай хуулийн 5.1, 7.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Махны үнийн хэт өсөлтийг сааруулах зорилгоор Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг аймгаас мах нийлүүлэх арга хэмжээг яаралтай зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр, дээгх аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Махны яармаг худалдааг Улаанбаатар хотод 2010 оны 6 дугаар сараас эхлэн хаврын улиралд сард 4 удаа, зун, намар, өвлийн улиралд сард 2-оос доошгүй удаа тус тус зохион байгуулан, махны эрэлт, нийлүүлэлтэд судалгаа хийж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.



3. Махны яармаг худалдааны үеэр эрүүл ахуй, ариун цэврийн хяналт, шалгалт, зөвшөөрлийн нэг цэгийн үйлчилгээ ажиллуулж байхыг нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Я.Содбаатар нарт үүрэг болгосугай.

4. 2011 оноос эхлэн Улаанбаатар хотод 12.0 мянган тонн, Дархан, Эрдэнэт хотод тус бүр 1.0 мянган тонн, бусад аймгийн төвүүдэд 100 тонноос доошгүй хэмжээний мах нөөцлөн, жил бүрийн хаврын улиралд борлуулах ажлыг зохион байгуулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Хаврын улиралд борлуулах нөөц махны урамшуулалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Мах бэлтгэн хадгалж, хаврын улиралд борлуулах шаардлага хангаж байгаа аж ахуйн нэгжүүдэд зээл олгон дэмжих ажлыг зохион байгуулахыг Монголбанкны ерөнхийлөгч Д.Пүрэвдоржид зөвлөсүгэй.

7. Өвс, тэжээл бэлтгэн нөөцлөх тогтолцоог боловсронгуй болгох, аймаг, сумын түвшинд тэжээлийн нөөц сан бий болгох талаар санал боловсруулж энэ оны III улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.

8. Дараахь ажлыг зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай:

8.1. хүнсний зориулалттай буудайн чанарыг сайжруулах зорилгоор үрийн тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжийг зохих журмын дагуу сонгон шалгаруулж хамтран ажиллах;

8.2. тариалангийн үйлдвэр эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд тэдгээрийн улсад болон гурилын үйлдвэрт нийлүүлсэн буудайд олгох мөнгөн урамшууллыг бүс, чанарын зэрэглэлээр ялгавартай тогтоон олгох талаар санал боловсруулж энэ оны 6 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулах;

8.3. элсэн чихэр, цагаан будаа, ургамлын тосны түүхий эдийг дотооддоо тариалах талаар хийж байгаа ажлыг эрчимжүүлэх, гадаад оронд газар түрээслэн авч эдгээр бүтээгдэхүүний тариалах асуудлыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах талаар тодорхой санал боловсруулж Засгийн газарт танилцуулах;



8.4. гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн болох мах, гурил, элсэн чихэр, цагаан будаа, ургамлын тосны бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд байгаа үлдэгдэл нөөцийн хэмжээг сар бүр нэгтгэн судалж, зохицуулж байх.

9. Мах, төмс, хүнсний ногооны зоорь, агуулахын аж ахуй эрхлэгчдийг урт хугацаатай, бага хүүтэй гадаадын зээл, тусламжид хамруулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

10. Сумдад ашиглаж байгаа агропаркийн ашиглалтыг сайжруулан, хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

11. Цагаан будаа, элсэн чихрийн нийлүүлэлтийг тогтвортой байлгах талаар нийлүүлэгч аж ахуйн нэгжийн удирдлагатай уулзалт зохион байгуулж, зохицуулалтын арга хэмжээг тогтмол авч ажиллахыг нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаярт даалгасугай.

12. Цагаан будааны нийлүүлэлтийн тогтолцоог найдвартай болгох зорилгоор томоохон экспортлогч орнуудын холбогдох байгууллагад энэ төрлийн бүтээгдэхүүн импортлох квот авах асуудлыг тавьж шийдвэрлүүлэхийг Гадаад харилцааны сайд Г.Занданшатарт даалгасугай.

13. Мах, сүү, төмс, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог зах зээлийн харилцаанд нийцүүлэн боловсронгуй болгох, орчин үеийн төрөлжсөн бөөний худалдааны төв, агуулах байгуулах, энэ төрлийн төслийг гадаадын зээл, тусламжид хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт тус тус даалгасугай.

14. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явц, үр лүнгийн талаар Засгийн газарт сар бүр танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 06 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар
хот

**Олон улсын хурал зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ази, Номхон далайн бүсийн шуудан холбооны гүйцэтгэх зөвлөлийн хурлыг 2011 онд Улаанбаатар хотод зохион байгуулахаар тогтсугай.
2. Хурлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хянаж Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.
3. Ази, Номхон далайн бүсийн шуудан холбооны гүйцэтгэх зөвлөлийн хурлын бэлтгэлийг сайтар хангаж зохион байгуулахыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЗРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 06 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах хөрөнгийг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, төсөвт

тусгах, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх зэрэг арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болд, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан "Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны дүрэм" /MNS/ISO 17799:2007/, "Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шаардлага" /MNS/ISO 27001:2007/ зэрэг стандартыг яам, Засгийн газрын агентлагуудад мөрдүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болд, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансар нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

**Засгийн газрын 2010 оны 141 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт**

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Мэдээлэл, харилцаа холбооны технологи манай орны нийгэм, эдийн засгийн амьдралд нэвтэрч, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын үйл ажиллагаа нь мэдээлэл, харилцаа холбооны технологитой салшгүй холбогдон, цахим засаг, цахим боловсрол, цахим эрүүл мэнд зэрэг мэдээлэлжсэн нийгмийн бүрдэл хэсгүүд үүсэн хөгжиж байгаатай уялдуулан мэдээллийн аюулгүй байдлыг хангах явдал нь өнөөгийн тулгамдсан асуудал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг болж байна.

Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлс, заналхийлж байгаа аюулыг судлан дүгнэсний үндсэн дээр мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар эрх зүйн орчныг бүрдүүлэх, бодлогыг тодорхой болгох, шинэ техник, технологи нэвтрүүлэх,



хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зах зээлийг бий болгож, хүний нөөцийг хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, аюул бодитой оршихын зэрэгцээ энэ нь хурдацтайгаар өсөн нэмэгдэж байна. Иймд олон улс, бүс нутгийн болон улс орнуудын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бий болгох, төрөл бүрийн кибер довтолгоон, халдлагаас хамгаалах, сөрөн зогсох талаар хамтын ажиллагааг хөгжүүлэх, хууль эрх зүйн зохицуулалтын орчин бий болгох, стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлэх зарчим, зорилт

2.1 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн (цаашид "Хөтөлбөр" гэх) зорилго нь Монгол Улсын төрийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын цахим мэдээллийн сан, мэдээлэл түүнийг дэмжих дэд бүтцийн цахим аюулгүй байдлыг хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулахад оршино.

2.2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

2.2.1. үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх;

2.2.2. мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар олон улсын чиг хандлага, стандартыг баримтлах;

2.2.3. төр-хувийн хэвшлийн түншлэл, иргэдийн оролцоог хангаж, тэдгээрийн уялдаа холбоог бэхжүүлэх;

2.2.4. онц чухал дэд бүтцийг хамгаалах арга хэмжээг төр анхааралдаа авахын зэрэгцээ төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг хослуулж хэрэгжүүлэх;

2.2.5. хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хэрэгжүүлэх;

2.2.6. мэдээллийн аюулгүй байдлыг хангах асуудлыг олон улсын хэмжээнд ил тод хамтын ажиллагааны зарчмаар хэрэгжүүлэх;

2.2.7. бизнесийн болон хувь хүний нууц, хүний эрхийг хүндэтгэх.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

Зорилт 1. мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Зорилт 2. мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, хариу үйлдэл хийх тогтолцоог бүрдүүлэх;

Зорилт 3. мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний соёл бий болгон



төлөвшүүлэх, иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийн таатай орчин бүрдүүлэх;

Зорилт 4. төрийн мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо бүрдүүлэх.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.3.1. холбогдох хуулийг шинээр боловсруулж батлуулах, даган мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;

2.3.2. мэдээллийн аюулгүй байдлын стандарт, аюулгүй байдлыг хангах чиглэлээр журам боловсруулж хэрэгжүүлэх;

2.3.3. мэдээллийн аюулгүй байдлыг хангах удирдлагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.

Мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, хариу үйлдэл хийх тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.3.4. мэдээллийн аюулгүй байдалд судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт өгч байх;

2.3.5. мэдээллийн аюулгүй байдлын будлиан /incident/, кибер гэмт хэрэг, кибер терроризмоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хариу үйлдэл хийх;

2.3.6. үндэсний аюулгүй байдалд чухал нөлөө бүхий онц чухал дэд бүтцийг хамгаалах;

2.3.7. интернэтийн аюулгүй байдлыг хангах;

2.3.8. мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн баталгаажуулалт, хөндлөнгийн хяналтын тогтолцоо бий болгож, эмзэг байдлыг бууруулах.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний соёл бий болгон төлөвшүүлэх, иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.3.9. мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн ажилтныг сургаж бэлтгэх, хүний нөөцийг хөгжүүлэх;

2.3.10. мэдээллийн аюулгүй байдлын талаар иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, соёлтой хэрэглээг бий болгож төлөвшүүлэх сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

2.3.11. мэдээллийн аюулгүй байдлыг хангахад төр-хувийн хэвшлийн түншлэлийг ашиглах;

2.3.12. мэдээллийн аюулгүй байдлын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх.

Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.3.13. төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, үнэлгээ хийх;

2.3.14. төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах;



2.3.15. шифр болон криптографын технологийг хөгжүүлж, хэрэглээг нэвтрүүлэх;

2.3.16. кибер гэмт хэрэг, кибер терроризмтой тэмцэх чадавхийг хөгжүүлэх, тэдгээртэй тэмцэх.

Гурав. Хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

3.1.1. төсвийн хөрөнгө;

3.1.2. хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө;

3.1.3. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт.

3.1.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ойролцоогоор 68.6 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдах тооцоо гарч байна.

№	Эх үүсвэр	Санхүүжилт (сая.төг)
1	Төсвийн хөрөнгө	35.5
2	Хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө	21.000
3	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	12.100
	Нийт	68.6

3.2. Хөтөлбөрийг 2010-2015 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

4.1. "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг "Монгол Улсын мянганы хөгжлийн зорилт", "Цахим монгол", "Бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр" болон холбогдох бусад төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, санхүүжилтийн асуудлыг шуурхай шийдвэрлэх, салбарын байгууллагуудын уялдаа холбоог хангах, үндэсний болон орон нутгийн түвшинд нэгдмэл удирдлагыг бий болгох, хандивлагчид, олон улсын байгууллагын оролцоог уялдуулан зохицуулах асуудлыг харилцаа холбооны болон тагнуулын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулна.

4.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт тус бүрийн хүрэх үр дүнгийн болон шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг гаргаж Засгийн газарт жил бүр танилцуулж байна.

Засгийн газрын 2010 оны 141 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДСЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа	Хүрэх үр дүн	Харууцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хяналтын эх үүсвэр, хэмжээ (байг.төг)
Зорилт 1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орныг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ						
1	Холбогдох хуулийг шинээр боловсруулж батлуулах дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах	а) Шинээр боловсруулж батлуулах: -Мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаархи хууль -Тоон гарын үсгийн талаархи хууль -Дата хамгаалах талаархи хууль б) нэмэлт, өөрчлөлт оруулах: -Харилцаа холбооны тухай хуулийн шинэчилсэн найруулга -Төрийн нууцын тухай хууль -Онц байдлын тухай хууль -Архивын тухай хууль -Зохиогчийн эрхийн тухай хууль -Слоуны өмчийн тухай хууль -Латентийн тухай хууль -Иргэний хууль -Бусад хууль тогтоомжууд (2010-2015 он)	Нийгэм, эдийн засгийн бүх салбарын мэдээлэл, харилцаа холбооны аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж мэдээлэл, харилцаа холбооны технологийн аюулт, суллагчийг аюулгүй байдал, кэртэй код, цахим гарын үсгийн талаар зохицуулалт бий болно	МШХХТТ, ТЕГ, ХЗДХР, ЗГХЗГ	Шинээр боловсруулсан болон нэмэлт, өөрчлөлт батлуулсан хуулийн 100	-
2	Мэдээллийн аюулгүй байдлын стандарт, аюулгүй байдлыг хангах чиглэлээр боловсруулж хэрэгжүүлэх	Төрийн бүх шатны байгууллага болон онц чухал дэд бүтэцэд мэдээллийн аюулгүй байдлын стандартуудыг мөрдүүлэх, гэрчилгээжүүлэх, баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх, хяналт тавих (2010-2012 он) Улсын улсын мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэцийн аюулгүй байдлын холбоотой бусад стандартыг үндэсний стандарт болгон батлуулж, бүх нийтээр дагаж мөрдүүлэх төлөвийн зохицуулалт хийнэ (2010-2011 он)	Стандартын шаардлага хангасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ бий болно	МШХХТТ, САСГ, ТЕГ, ЗГХЗГ	Стандарт шаардлага хангасан гэрчилгээ бүхий байгууллага, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо	Улсын төсөв 100



	<p>Асуутуй байдлыг хангах чиглэлээр шахаар боловсруулан батлуулах, мөрдүүлэх журам</p> <p>-Төрийн цахим мэдээлэл солилцох талаархи журам</p> <p>-Төрийн өгөгдлийг хамтран ашиглах өгөгдлийн санд хандах талаархи журам</p> <p>-Төрийн өгөгдөлд захирах хяналтын үүрэгдэлийн талаархи журам</p> <p>-Тоон гарын үсэг ашиглах талаархи журам</p> <p>-Төрийн ажиллагааг хангах, сурталчилуулах талаархи журам</p> <p>-Бусад шаардлагатай журам, дүрмүүд (2010-2014 он)</p>	<p>Үйл ажиллагааны дэх журмыг тогтоох замаар мэдээллийн нууцлал, хяналтлага тодорхой болно</p>	<p>МШХХТТ, МХЕГ</p>	<p>Мэдээллийн асуутуй байдлын тухай хууль, тогтоомж, стандарт журмын 100</p>	<p>Улсын төсөв 100</p>
	<p>Төрийн болон онц чухал дэд бүтэц бүхий байгууллагад мэдээллийн асуутуй байдлын стратеги, бодлого, холбогдох журмыг батлуулах мөрдүүлэх, хяналт тавих (2010-2012 он)</p>	<p>Төрийн болон онц чухал дэд бүтэц бүхий байгууллагын мэдээллийн асуутуй байдлын бодлого, чиглэл тодорхой болно</p>	<p>ЗГХСГ, МШХХТТ, ТЕГ, МХЕГ</p>	<p>Батлагдан бодлого, төлөвлөгөө, журам</p>	<p>Улсын төсөв 100</p>
	<p>Хууль хяналтын байгууллагын ажилтанд шибэр гэмт хэргийн ойлголт, мэдээл олгох, түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх арга тохиромжтой азмаллуулж, сургах (2010-2013 он)</p>	<p>Шүүх байгууллагын кибер гэмт хэргийг шийдвэрлэх талаархи мэдээл олгох болно</p>	<p>Хууль хяналтын байгууллага, МШХХТТ, ЦЕГ</p>	<p>Сургалтад хамрагдан байгууллага, ажилтны 100</p>	<p>Улсын төсөв 100</p>
<p>3</p> <p>Мэдээллийн асуутуй байдлыг хангах үүрэгдэлийн тогтолцоо, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох</p>	<p>Улсын мэдээллийн асуутуй байдлын асуудал хяналтын төрийн захиргааны байгууллага бий болгох асуудлыг судалж, зохиц журмын дагуу шийдвэрлэх (2011-2012 он)</p> <p>Төрийн болон онц чухал дэд бүтэц бүхий байгууллагын мэдээллийн асуудал хяналтын асуудал хяналтын нэгж байгуулах (2010-2012 он)</p>	<p>Мэдээллийн асуутуй байдлын асуудал хяналтын үүрэгдэлийн талаархи мэдээл олгох болно</p>	<p>МШХХТТ, ЗГХСГ</p>	<p>Улсын төсөв 1500</p>	<p>Улсын төсөв 500</p>

	Мэдээллийн аюулгүй байдлын зөвлөлийг байгуулах (2010 он)	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	ЗГХЭГ, ТЕТ, МШДХТГ	
Сорилт 2. Мэдээллийн аюулгүй эмзэг байдлыг бууруулах, харму үйлдэл хийх тогтолцоог бүрэлдүүлэх зорилтот дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	ЗГХЭГ, ТЕТ, МШДХТГ	-
	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	ТЕТ	Судалгаа шинжилгээний чанар, 100
1	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	ТЕТ, МШДХТГ	Улсын төсөв 1000
2	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	МШДХТГ, ТЕТ, ЗОХШ	Гадаадын эзэл, тусламж 5000
2	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах салбар хоорондын ажлын уялдаа холбоо сайжирна	Зөвсэгт хүчний кибер довтолгооны эсрэг харуу үйлдэл хийх тогтолцоог бүрэлдүүлэх	Улсын төсөв 1500



	<p>Мэдээллийн аюулгүй байдлын аргаар халдлага, довтлоогсон, будлиан, учралын талаар нэн даруй мэдээлэх үндэс, соёлыг олон нийтэд төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх (2010-2015 он)</p>	<p>Мэдээллийн технологийн соёлтой, өс зүйтэй харагдах бий болно</p>	<p>МШХХТТ</p>	<p>Хариу үйлдэл үзүүлэгдсэн кибер халдлага, будлианы тухай мэдээлэл</p>	<p>Улсын төсөв 100</p>
	<p>Кибер гэмт хэргийг, кибер терроризмтой тэмцэх асуудал хармуудсан нэгжийг Цагдаагийн ерөнхий газар, Талуулын ерөнхий газарт бий болгох асуудлыг судлах зөвхө журмын дагуу шийдвэрлүүлэх (2010-2012 он)</p>	<p>Кибер гэмт хэргийн илрүүлэлт, хэрэг бүртгэл, шүүхийн шалгалттай чадварыг сайжиргах</p>	<p>ТЕГ, ЦЕГ</p>	<p>Шүүн таслагдсан кибер гэмт хэргийн тоо</p>	<p>Улсын төсөв 2500</p>
	<p>Кибер орон зайн халдлага, байгалийн гамшгийн үед мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг сэргээн амжуулах, хариу үйлдэл үзүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг авч байх (2010-2015 он)</p>	<p>Кибер халдлага, байгалийн гамшгийн үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэх болно</p>	<p>МШХХТТ, ТЕГ, ЗӨЖШ, ОБЕГ</p>	<p>Батлагдсан төлөвлөгөөний тоо</p>	<p>Улсын төсөв 50</p>
	<p>Кибер терроризмтой тэмцэх, кибер гэмт хэргийн ул мөр, нотлох баримтыг бэхжүүлэх, хэргийн гэдэвг үзэх хийх, компьютерийн криминалистик техникийн шинжилгээ (forensic analysis) хийх үндэсний чадварыг бий болгох, холбогдох төмөр хэрэгсэл, програмыг хангамаар хангах, хүний нөөцийг хөгжүүлэх (2010-2015 он)</p>	<p>Цагдаа, хууль хяналтын байгууллагын чадварыг сайжирсан байна</p>	<p>ЦЕГ, ТЕГ</p>	<p>Илрүүлсэн кибер гэмт хэргийн тоо</p>	<p>Улсын төсөв 5000</p>

	<p>Кибер гэмт хэргийг мөрдөх аргачлал, хэргийн газрын үзлэг хийх аргачлалын удирдамж, газрын авлага боловсруулах, хэвлүүлэх, нийт хэрэг бүртгэлч, мөрдөн байцаагч, криминалистикийн шинэчлэлийг сургалтад хамруулах, кибер гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээл, чадвар бий болгох, хягжүүлэх (2010-2015 он)</p>	<p>Цагдаа, хууль яамангийн байгууллагын ажилтнуудын мэдээл чадвар дээшлэх болно</p>	<p>МШХХТГ, ЦЕГ, ТЕГ</p>	<p>Сургалтад хамрагдсан ажилтны 100</p>	<p>Улсын төсөв 200</p>
	<p>Үндэсний аюулгүй байдалд нөлөө бүхий онц чухал дэд бүтцийг тасархайлох (2010-2015 он)</p>	<p>Осол, халдлага, байгалийн гамшгийн дараа мөхөн сүргээх хугацаа тасархай болно</p>	<p>ТЕГ</p>	<p>Баллаарсан төлөвлөгөөний 100</p>	
	<p>Онц чухал объект хамгаалах, тэдгээрийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, будаман, учрал, осол, аваарын дараа сүргээн ажиллуулах, үнэрч болох аюулгүй бүүрүүлэх төлөвлөгөөг батлуулах хэрэгжүүлэх (2010-2015 он)</p>				
3	<p>Үндэсний аюулгүй байдалд нөлөө бүхий онц чухал дэд бүтцийг хамгаалах</p>	<p>Онц чухал объект, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан байгууллага болон төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн хооронд мэдээллийн аюулгүй байдлын бүрдвэл, халдлага, эрсдэлийн талаар мэдээлэл солилцох системийг бий болгох (2010 он)</p>	<p>Кибер гэмт хэрэг, будаманы талаар төрийн болон бизнесийн байгууллага, иргэдийн хооронд мэдээлэл шуурхай солилцох боломж бүрдэх болно</p>	<p>Олон нийтад хүргэгдсэн мэдээлэл, анхааруулгын 100</p>	<p>Улсын төсөв 100</p>
	<p>Цэвэр мэдээллийн аюулгүй байдлын анхааруулга, мэдээллийн системийг бий болгох (2010 он)</p>	<p>Кибер гэмт хэрэг, халдлага, будаманы мэдээлэл солилцох автомат систем бий болж эрсдэлийг даван туулах боломж нэмэгдэх болно</p>	<p>ТЕГ, МШХХТГ</p>	<p>Солбицсон мэдээллийн 100, чанар</p>	<p>Улсын төсөв 1200</p>



		Онц чухал объектын үйл ажиллагаанд мэдрэлтэй аюулгүй байдлын талаар хөндлөнгүйн өвчлөлт тогтмол хийх, ашиглаж байгаа мэдрэлэл боловсруулах, дамжуулах, хадгалах тэнгэр төхөөрөмж, техник хэрэгсэл, програмын хангамжийг баталгаажуулах (2010-2015 он)	Төрийн болон онц чухал дэд бүтэц бүхий байгууллагын тэнгэр төхөөрөмж, програмын хангамжийг баталгаажуулах	ТӨГ, МШДХХТТ, ХХЗХ	Баталгаажуулагдсан мэдрэлтэй системийн 100	Улсын төсөв 1000
		Төрийн холбооны газрыг мэдрэлтэй аюулгүй байдлыг хангах чиглэлээр өөрчлөн зохион байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх (2011-2012 он)	Мэдрэлтэй аюулгүй байдлыг хангах асуудал төлөрхой болно	ТӨГ, МШДХХТТ, ХХЗХ	-	-
		Интернетийн үйлчлэлээ үзүүлэх байгууллага, хэрэглэгчдэд интернетийн аюулгүй, хүртээмжтэй хэрэглээг бий болгох, техник, технологийн зохицуулалтын арга хэмжээ авах (2010-2014 он)	Интернетийн хэрэглээ найдвартай, аюулгүй болно	МШДХХТТ, ХХЗХ	Зохицуулалтын арга хэмжээ хэрэгжсэн интернетийн үйлчлэлээ үзүүлэгчийн тоо	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 2000
Интернетийн аюулгүй байдлыг хангах		Монгол Улсын интернетийн дэд бүтцийг сайжруулах, домэйн нэрийн сервер, вэб хуудас, дотоод болон гадаад харилцан холбоотыг хамгаалах, домэйн нэрийн борлого төлөрхойлөх (2010-2014 он)	Монгол Улсын интернетийн орчныг аюулгүй болно	МШДХХТТ, ХХЗХ	-	-
		Интернет ашиглан гэмт хэрэг үйлдэх, сардар самуун, хүчирхийлэл зэрэг зүйл бус үзэгдлийг сурталчлах, ёс бус мэдрэлэл, аюулга тарахаас урьдчилан сэргийлэх, дотоодын болон гадаадын байгууллагатай хамтран интернет хостуудад шалгалтыг тогтмол хийх (2010-2015 он)	Интернетийн эвч, зохицтой хэрэглээ бий болж вэб хуудсууд Монгол Улсын хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг болно	МШДХХТТ, ТӨГ, ХХЗХ	Хууль зөрчсөн мэдрэлэл бүхий вэб хуудсуудын тоо	Улсын төсөв 50
		Хүүхдийн интернетийн орчинд хамгаалах арга хэмжээ авах, зурж эх, багш, сурган хүмүүнүүдэд боловсролыг эрсдэл, аюулгүйн талаар мэдрэлэл, агуулгад өвчлөлт хийх (2010-2015 он)	Хүүхэд интернетийн орчинд аюулгүй суралцах боломж бий болно	МШДХХТТ, МХЕГ	Интернетийн орчинд хүүхдийн хамгаалах мэдрэлтэй болон сургалчлаганы арга хэмжээний тоо	Улсын төсөв 100

	<p>Интернет хэлэлцүүлэг, чат болон бусад интернэтэд суурилсан харилцаа холбооны хэрэгсэл ашиглан хууль бус мэдээлэл тархах нөхцөлийг хялах төлөв, програмын хангамжийн арга хэмжээ авах (2010-2014 он)</p>	<p>Монгол Улсын хуулийн дагуу интернэтийн зөв хэрэглээ бий болно</p>	<p>МШХХТГ, ХХЗХ</p>	<p>Программ төлөхийн арга хэмжээ авсан үзүүлэлт</p>	<p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1000</p>
	<p>Үйлдвэрлэлийн албан ёсны лиценз бүхий програмын хангамж ашиглах явдал, дамжих, зохиогчийн эрхийн талаархи хууль тогтоомжийн хэрэгсэлийг хангуулах (2010-2015 он)</p>	<p>Баталгаатай програмын хангамжийг ашиглах, үйлчилгээ авах боломж бүрдэх болно</p>	<p>МШХХТГ, Оюуны өмчийн газар, ХХЗХ</p>		
	<p>Олон улсад хүлээн зөвшөөрсөн програмын хангамж, төлөв хангамж үйлдвэрлэлийн албан ёсны салбарыг Монгол Улсад нээж програмын хангамж, төлөв хангамжийн борлуулалтын дараахь үйлчилгээг хургах тавтай нөхцөлийг бүрдүүлэх (2010-2015 он)</p>	<p>Гараадын програмын хангамжийн үйлчилгээг шуурхай авах замаар мэдээллийн системийн мэдээллийг ажиллагааг хангах</p>	<p>МШХХТГ, МТҮП</p>	<p>Борлуулалтын дараахь үйлчилгээ эрхлэгчийн тоо</p>	
	<p>Төрийн байгууллага, өнц чухал дэд бүтэц бүхий байгууллагад ашиглагдах програмын хангамжийг туршиж, програмын алдааг илрүүлэхтэй холбогдсон нэгж бий болгох, туршилтыг давсан бүтээгдэхүүнийг зоргоо, баталгаажуулах (2010-2015 он)</p>	<p>Төрийн байгууллагад ашиглагдаж байгаа програмын хангамжийн чанар, аюулгүй байдал баталгаажна</p>	<p>ТЕГ, МШХХТГ, ХХЗХ, МТҮП</p>	<p>Туршилтад хамрагдсан програмын хангамжийн тоо</p>	<p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1000</p>
	<p>Дотоодын програмын хангамж үйлдвэрлэл, програмын хангамжийн аугсгорын эрхлэгч мэдээллийн аюулгүй байдал, чанарын тогтолцоо нэвтрүүлэхийг дэмжих (2010-2015 он)</p>	<p>Дотоодын програмын хангамжийн чанар, стандартын шаардлага хангагдаж аюулгүй байдал дээшлэх болно</p>	<p>МШХХТГ, МТҮП</p>	<p>Баталгаан мэдээллийн төлөвний удирдлага, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын стандартын тоо</p>	

	Компанийн хортой кодын эсрэг програм хангамж болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилготой бүхий тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх арга хэмжээ авах (2010-2014 он)	Мэдээллийн аюулгүй байдлын техник хэрэгсэл, програм хангамж эрсдэлийг бууруулах	МШХХТ	Татвараас чөлөөлөгдсөн тоо байдал	
	Төрийн байгууллагын мэдээллийн технологийн худалдан авалт, засвар үйлчилгээ, хөгжүүлэлтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоонд оруулах (2010-2015 он)	Төрийн мэдээллийн систем нэгдсэн бодлогын дагуу хэрэгжих болно	МШХХТ, ТЕТ, СЯ		
	Төрийн байгууллага, өнц чухал обьектад ашиглагдах мэдээлэл, харилцаа холбооны төлөм хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шалган баталгаажуулах, гэрчилгээжүүлэх лаборатори байгуулах (2010-2015 он)	Төрийн мэдээллийн технологийн тоног, төхөөрөмж, програмы хангамж баталгаажуулагдана	МШХХТ, ХХЗХ, ТЕТ	Баталгаасан техник хэрэгсэл, програмы хангамжийн тоо	Улсын төсөв 1000
	Мэдээллийн аюулгүй байдлын хөндлөнгийн хяналт хийх байгууллагад танигдах шаардлага, тусгай зөвшөөрлийг бий болгох (2010 он)	Мэдээллийн аюулгүй байдлын хөндлөнгийн хяналтын тогтолцоо бий болно	ХХЗХ, МШХХТ	Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх тусгай зөвшөөрөл бүхий байгуулла-гуудын тоо	Улсын төсөв 1000
	Зорилт 3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний соёл бий болгон төлөвшүүлэх, иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийн таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ.				
	Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэжлэн ажилтныг сургаж бэлтгэх, хүний нөөцийг хөгжүүлэх	Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуульд мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаархи ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах (2011 он)	БСШУЯ, МШХХТ	Мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдлэг эзэмшсэн суралчдын тоо	Улсын төсөв 10
1	Мэдээлэл, харилцаа холбооны мэргэжлийн сургуульд мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинэ мэргэжил нэрх, мэргэжлэн ажилтан бэлтгэх (2010 он)	Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлд нарийн мэргэжлийн ажилтан бэлтгэгдэнэ	БСШУЯ, МШХХТ	Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтний тоо	Улсын төсөв 1000

		Мэдээллийн аюулгүй байдлын талаар мэргэжлүүлэх сургалтын тогтолцоог бий болгох, төрийн байгууллага болон онц чухал объектад ажиллах мэдээллийн технологийн ажилтан, мэдээллийн аюулгүй байдлын ажилтан, систем администраторыг зохиж сургалтад хамруулж, гэрчилгээжүүлэх (2011 он)	Мэдээллийн аюулгүй байдлын талаар мэргэжилтэн бэлтгэгдэж буй байдлын мэдээлсэн мэргэжилтэн байгаагүй	БСШУЯ, МШДХХТ, ТЕГ	Мэргэжилтний тоо	Улсын төсөв 500
		Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр багшлах, онц чухал дэд бүтэцэд ажиллах нэрийн мэргэжлийн ажилтны гадаргад сургах, мэргэжлүүлэх, энэ чиглэлээр онлайн хэлбэрийн сургалт явуулах (2011-2015 он)	Мэдээллийн аюулгүй байдлын талаар мэргэжилсэн ажилтны чадавхи сайжирч а	БСШУЯ, МШДХХТ, ТЕГ	Өндөр зэрэглэлийн мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтний тоо	Гараадын эзэл тусламж 1500
		Төрийн хэмжээнд албан хаагчийн шалгалтын төстэд мэдээллийн аюулгүй байдлын талаархи асуудлыг оруулах, тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтод энэ талаар зохиж шаардлагыг тусгах (2010-2015 он)	Төрийн хэмжээнд албан хаагчид мэдээллийн аюулгүй байдлыг илүүдлэл, хамгаалалтын талаар мэдээлэгдэж байна	ТАЗ, МШДХХТ, ТЕГ	Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжлэгч төрийн хэмжээнд албан хаагчийн тоо	Улсын төсөв 50
2	Мэдээллийн аюулгүй байдлын талаар иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, ойлголттой хэрэглээг бий болгох төлөвшүүлэх сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Мэдээллийн аюулгүй байдлын талаар олон нийтэд тодорхой мэдлэг, ойлголт бий болгох зорилготой төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах (ТБ нэвтрүүлэг, вэб сайт, форум, нийтлэл, хөшөө, ном гэх мэт) (2010-2015 он)	Олон нийтийн мэдээллийн аюулгүй байдлыг уламжар, мэдлэг дээшлэх болно	МШДХХТ, ХХЗХ	Нийтэд зориулсан арга хэмжээний тоо, чанар	Төсөв, хувийн хэргийн хөрөнгө оруулалт 100
		Бичиг болон хяналт, дүнд бизнес эрхлэгчид мэдээллийн аюулгүй байдлын ойлголт, мэдлэг олгох (2010-2015 он)	Жижиг, дунд бизнес эрхлэгчид мэдээллийн аюулгүй байдлын талаар арга хэмжээ авч а	МШДХХТ	Сургалтад хамрагдсан бизнес эрхлэгчдийн тоо	-



		Зөвлөлийн эрх, оюуны өмчийн эрхийг хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах (2010-2015 он)	Оюуны өмг, хууль бус агуулга, программ хангамжаар дамжин үүсэж болох эрсдэлт байдлыг болгоно	Оюуны өмчийн газар		
	Мэдээллийн агуулгуй байдлыг хангахад төр-хувийн хэвшлийн түншлэлийг ашиглах	Хувийн хэвшлийн байгууллагад кибер халдлагатай тэмцэх баг бий болгох адрлыг дэмжих (2010-2015 он)	Томоохон хувийн хэвшил, салбарын хэмжээний кибер агуулгуй байдлыг хангах тогтолцоо бий болно	МШХХТТ	Шинээр байгуулагдсан байгын тоо	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 2000
3		Мэдээллийн агуулгуй байдлын зөвлөх үйлчилгээ, хөндлөнгийн хичээлэн зах зээлийг бий болгох, дотоодын тоног төхөөрөмж, программ хангамжийн үйлдвэрлэлийг дэмжих, татварын хөнгөлөлт үзүүлэх (2010-2015 он)	Дотоодын нөөц бололцоонд тушиглан программ хангамжийн эрсдэлийг бууруулна	МШХХТТ, СЯ		
	Мэдээллийн агуулгуй байдлын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийнэ	Мэдээллийн агуулгуй байдлыг хангах чиглэлээр хийх эрдэм шинжилгээний ажлыг дэмжих замаар судалгааны баг бий болгож, судалгааны үр дүнд тулгуурлан үндэрсний кэдрчлөл, стандартыг бий болгох (2011 – 2015 он)	Мэдээллийн агуулгуй байдал, нууцлалын үндэрсний эрдэм шинжилгээ, судалгааны тогтолцоо бий болно	БСШУЯ	Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн тоо	Улсын төсөв 100
4		Ес зүйт хавчрын талаар эрх зүйн орчин бүрдүүлэх (2011-2015 он)	Мэдээллийн агуулгуй байдлын эрх зүйн орчин өсж тогтоож хүний нөөцийн чадавхи дээшлэнэ	ТЭГ, МШХХТТ	Ес зүйт хавчрын тоо	
Зорилт 4. Төрийн мэдээллийн агуулгуй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ.						
	Төрийн мэдээлэл, харилцаа харицлаа дэд бүтцийн эмзэг, сун байдлыг илрүүлэх, үнэлгээ хийх	Төрийн мэдээллийн агуулгуй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагын чадавхийг бэлтгүүлэх (2010-2015 он)	Төрийн мэдээллийн агуулгуй байдлын багалааг хангах үндсэн чиг үүрэг хэрэгжүүлнэ	ТЭГ, МШХХТТ		Гадаадын зээл, туслах 2500
1						

<p>Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын талаархи хөндлөнгийн хяналтыг тогтоолжуулах, хүний нөөцийг сургаж болгох (2010-2015 он)</p>	<p>Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг бодилоор үнэлэх, шаардлагатай арга хэмжээг түргэн шуурхай авах боломж бүрдэх болно</p>	<p>ТӨГ, МШХХТГ</p>	<p>Мэдээллийн аюулгүй байдлын талаар хөндлөнгийн хяналт хийгдсэн байгууллагын тоо</p>	<p>Улсын төсөв 500</p>
<p>Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг тогтоолжуулах, нэвтрүүлсэн эхэлж сул талыг арилгах, эрсдэлийг бууруулах техник, програмын хяналтын арга хэмжээг алах (2010-2015 он)</p>	<p>Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хянаж асуудал сайжирна</p>	<p>ТӨГ, МШХХТГ</p>	<p>Төрийн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн бууралт</p>	<p>Улсын төсөв 3000</p>
<p>Төрийн байгууллагын мэдээллийн системийн ашиглалт үйлчилгээг Аугсгорсинг ашиглан хэрэглүүлэх, хяналт тавих (2010-2015 он)</p>	<p>Төрийн мэдээллийн системийн үйлчилгээг чанартай, шуурхай баталгаатай болно</p>	<p>Тухайн байгууллага</p>	<p>Аугсгорсинг үйлчилгээ авсан байгууллагын тоо</p>	<p>-</p>
<p>"Үндэсний дата төв"-ийн аюулгүй байдал төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хянах "Мэдээллийн аюулгүй байдлын мониторинг, хяналтын төв"-ийг байгуулж, үйл ажиллагааг тогтоолжуулах (2010-2012 он)</p>	<p>Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг тасралтгүй хянах, мэргэжлийн шуурхай хариу үйлдэл үзүүлэх нөхцөл бүрдэх болно</p>	<p>МШХХТГ, ТӨГ</p>	<p>-</p>	<p>Гадаадын зээл, тусламж 10000</p>
<p>Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагад мэдээллийн технологийн асуудал хариуцсан ажилтны орон 100 бий болгох (2010 он)</p>	<p>Төрийн мэдээллийн аюулгүй байдлын удирдлага хянагдана</p>	<p>ЗГХЭГ, ТӨГ, МШХХТГ</p>	<p>Мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтны тоо</p>	<p>-</p>



		Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлийн үндэсний стандартыг төрийн бүх шатны байгууллагад мөрдүүлэх төрөөхийн зохицуулалтыг хийх, гэрчилгээгээрүүлэх (2010-2011 он)	Мэдээллийн аюулгүй байдлын талаархи стандартын шаардлага хангагдана	ЗГХЗГ, МШОХТГ, ТЕГ, СХЗГ	Батлагдан мөрдөгдөж буй стандартууд (Төсөөхийн зохицуулалтын тоо)	Улсын төсөв 300
		Төрийн үйл ажиллагаанд ашиглаж болох аюулгүй үйлдлийн систем, өргөн хэрэглээний програмыг хангамжийг өөрийн нөөц боловцоонд үндэслэн боловсруулах ажлыг дэмжих, чөлөөт болон нээлттэй эдийн програмыг хангамжийг нэвтрүүлэх (2010-2015 он)	Монгол Улсын стандарт, чанар, аюулгүй байдлын хяналтаар баталгаажсан програмыг хангамжийг ашиглаж нөөцөл бүрдэх болно	МШОХТГ, ТЕГ, МТУП	Боловсруулагдсан програмыг хангамж үйлдлийн систем	Улсын төсөв 1000
2	Төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах	"Үндэсний дата төв"-ийг түшиглэн төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгож, аюулгүй байдлыг хангах (2011-2012 он)	Төрийн мэдээллийг аюулгүй цахим орчинд солилцох, бүх төрлийн цахим үйлчилгээг төр үзүүлэх боломж нээгдэх болно	МШОХТГ, ТЕГ	Төрийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байгууллагын тоо	Улсын төсөв 7000
		"Үндэсний дата төв"-ийн нөөц төвийг байгуулах (2010 он)	Үндэсний дата төвийн нөөц байгуулагдаж төрийн мэдээллийн аюулгүй байдал хангагдах болно	МШОХТГ, ТЕГ	Нөөцийн төвийг байгуулсан байна	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 5000
3	Шифр, криптогра-фийн технологийг хөгжүүлж, хэрэглээг нэвтрүүлэх	Тоон гарын үсэг, нийтийн түлгүүрийн үндэсний дэд бүтцийг бий болгох замаар төрийн үйлчилгээ, Банк санхүү, цахим бизнес, худалдаа гэх зэрэг үйлчилгээг цахим орчинд аюулгүй хэрэглүүлэх боломж бүрдүүлэх (2010-2011 он)	Нийтийн түлгүүрийн дэд бүтэц нийгэм, эдийн засгийн бүх салбарт нэвтрэгдсэн байна	МШОХТГ, ТЕГ	Тоон гэрчилгээ авсан хуулийн этгээдийн тоо	Гадгаарын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1000

<p>Звэсэт хүний ангил, байгууллагыг шифр, криптографийн програмыг техник хэрэгслээр хангах (2011-2012 он)</p>	<p>Звэсэт хүний мэдээллийн нууцлал хангагдах болно</p>	<p>БХЯ, ЭХЖШ</p>	<p>Шифр, криптографийн програмыг хэрэгслээр хангагдсан тоо</p>	<p>Улсын төсөв 1000</p>
<p>Төрийн мэдээллийн системд хандах эрх, хяналтын удирдлагын тасгаар холбогдох журам боловсруулан хэрэгжүүлэх, техникийн шийдэл нэвтрүүлэх (2011-2012 он)</p>	<p>Төрийн мэдээллийн системд нууц бусгаар хандах боломжгүй болно</p>	<p>ТЕГ, МШХХТТ</p>	<p>Батлагдсан бодлогын баримт бичиг</p>	<p>Улсын төсөв 1000</p>
<p>Иргэний ухаалаг үнэмлэх түүнтэй холбоотой мэдээллийн агуулгыг байдлыг сайжруулах (2010-2015 он)</p>	<p>Бүртгэлийн гэгдсэн тогтолцооны агуулгыг байдал дээшлэх болно</p>	<p>ТЕГ, УБЕГ, МШХХТТ</p>	<p>Ологдсон иргэний ухаалаг үнэмлэхийг 100</p>	<p>Улсын төсөв 1000</p>
<p>Төрийн мэдээллийн гэгдсэн сүлжээ болон мэдээлэл солилцох дэд системийн агуулгыг байдлыг хангах, байгын VPN холболт үүсгэх, тоон гарын үсэг болон шифрлэх технологийг ашиглан харилцах нөхцөлийг бүрдүүлэх (2010-2015 он)</p>	<p>Төрийн цахим мэдээлэл солилцоо бүрэн нууцлагдана</p>	<p>ТЕГ, МШХХТТ, УДТ</p>	<p>Тусгай холбоо ашиглах байгууллагын тоо</p>	<p>Гадаадын эзэл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1000</p>
<p>Криптографийн мэргэжилтэнг гадаадын өндөр хөгжилтэй оронд бэлтгэх, криптограф, криптоанализийн лаборатори байгуулах (2010-2015 он)</p>	<p>Үндэсний нууцлалын технологи бий болно</p>	<p>ТЕГ</p>	<p>Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо</p>	<p>Улсын төсөв 2000</p>

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 06 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 147

Улаанбаатар
хот

**Хамгаалалтын захиргаа байгуулах
тухай**

Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг хадгалж хамгаалах, судлах, сурталчлах үүрэг бүхий Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааг байгуулсугай.

2. Хамгаалалтын захиргааны бүтэц, орон тооны дээд хязгаар болон дүрмийг баталж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт үүрэг болгосугай.

3. Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны зардлыг 2011 оноос эхлэн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medeelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 3.25

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487